

## ХЭНТИЙ, ДОРНОД, СҮХБААТАР АЙМАГТ АЖИЛЛАСАН ТУХАЙ

Зам, тээврийн хөгжлийн яамны 2016 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын баталсан 38-07-002/14 дугаартай хяналт шалгалтын удирдамжийн дагуу Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Автотээврийн төвийн тээвэр зохицуулалт, техникийн хяналт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд “Төрийн хяналт шалгалтын тухай” хууль, “Автотээврийн тухай” хууль болон түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд шалгалт хийж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Хяналт шалгалтыг ХШҮДАГ-ын ЗТХХ-ийн дарга С.Дорждагва ахлаж, ахлах мэргэжилтэн Д.Энх-Амгалан, Э.Оюунтунгалаг, мэргэжилтэн Н.Уугандулам нар 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 5 хоног ажиллалаа.

### **Хяналт шалгалтанд хамрагдсан объект**

“АТҮТ” ААТТӨҮГ-ын Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг дахь автотээврийн төвүүд, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “АйсВН” ХХК, “Дарьганга өртөө” хоршоо.

### **Хяналт шалгалтанд хамрагдсан объектын талаар товч мэдээлэл**

“АТҮТ” ААТТӨҮГ-ын Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг дахь автотээврийн техникийн хяналтын үзлэгийн төвүүд нь 2005 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

“АйсВН” ХХК нь Улаанбаатар – Дорнод – Улаанбаатар чиглэлд 2008 он, “Дарьганга өртөө” хоршоо нь Улаанбаатар – Сүхбаатар - Улаанбаатар чиглэлд 2011 оноос эхлэн хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг эрхэлж байна.

### **Хяналт шалгалтын явцад хийгдсэн ажил**

“Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг эрхлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ын дагуу Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Автотээврийн техникийн хяналтын үзлэгийн төвийн эрсдэлийг тооцоход Хэнтий-35% “дунд эрсдэлтэй”, Дорнод-19% болон Сүхбаатар- 24% “бага эрсдэлтэй” гэж тус тус дүгнэгдсэн ба илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 3 албан шаардлага өгсөн.

Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагааг МХЕГ-ын даргын баталсан 5.21 кодтой “Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагыг шалгах хяналтын хуудас”-ын дагуу эрсдэлийг тооцоход “Айс ВН” ХХК 87 оноо бүхий 30%-тай, “Дарьганга өртөө” хоршоо 90 оноо бүхий 31%-тай “Дунд эрсдэлтэй” гэж дүгнэгдсэн байна.

Шалгалтын явцад Улаанбаатар – Хэнтий аймгийн чиглэлд тээвэрлэлт гүйцэтгэж байсан “Бид анд нар” ХХК-ийн эзэмшлийн 7304УНТ дугаартай автобусны урд байрлуулсан лед гэрлийг газар дээр нь авахуулж, шалгалтад хамрагдсан байгууллагуудын тээврийн хэрэгслийн нэмэгдэл гэрлүүдийг авах талаар анхааруулга өгч ажилласан.

Хяналт шалгалтын явцад хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч болон техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэгч аж, ахуйн нэгж,

байгууллагуудын удирдах албан тушаалтан, ажилтнуудад уг ажил, үйлчилгээг хууль тогтоомж, стандартын дагуу хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах тухай улсын байцаагчийн 38-07-076/05-07, 38-07-003/08-09 дугаар албан шаардлагуудыг шалгалтад хамрагдсан байгууллагуудад хүргүүлсэн.